


# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

03.02 - 03.06



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**АНУ:** Энэ долоо хоногт COVID-19-ийн тархалттай холбоотой тодорхойгүй байдлаас үүдэн АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй байлаа. Зах зээлийн үнэлгээ өндөртэй индексүүд болон технологийн салбарын компаниудын илүү агуулдаг Nasdaq Composite индекс өсөлттэй байсан бол зах зээлийн үнэлгээ багатай индексүүд уналттай хаагдлаа.

S&P 500 индексийн сагсанд багтах харьцангуй тогтвортой байдаг ус, цахилгаан дулааны салбар хамгийн их өсөлттэй байлаа. Мөн, эрүүл мэндийн салбарын компаниудын хувьцаа мөн өсөлттэй байлаа. Энэхүү өсөлт нь АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн анхан шатны үе буюу Супер Мягмар гарагийн үр дүнгээр дэд ерөнхийлөгч асан Жо Байден сайн үзүүлэлттэй байгаа нь Сенатор Берни Сандерсийн "Medicare for All" системийн ирээдүйд сөргөөр нөлөөлсөн нь холбоотой. Харин эрчим хүчний салбар хамгийн их бууралттай байсан ба энэхүү бууралт нь ОПЕС-ийн орнууд ОПЕС-ийн гишүүн бус ОХУ-ийг газрын тос үйлдвэрлэлээ бууруулах тохиролцоонд хүрч чадаагүйтэй холбоотой.

**Европ:** Коронавирусын хурдацтай тархалт дэлхийн эдийн засгийн уналтад хүргэх айдсаас үүдэн энэ долоо хоногт Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд бууралтаа хэвээр байлаа. Хэдийгээр COVID-19-ийн хурдацтай тархалтын сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр Европын улсуудын хэрэгжүүлж буй эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээтэй холбоотой индексүүд өссөн ч долоо хоногийн сүүл гэхэд индексүүд бууралттай хаагдсан байна.

Европын зарим томоохон улсууд коронавирусын тархалтын сөрөг нөлөөний эсрэг сангийн бодлого хэрэгжүүлж эхлээд байна. Тархалт хамгийн их байгаа Итали улс, хохирол их амсаад буй хойд бүс нутагтаа 0.9 тэрбум еврогийн идэвхжүүлэлт явуулсны дараагаар 3.6 тэрбум еврогийн идэвхжүүлэлт явуулсан ба сүүлд энэхүү зардлыг 2 дахин ихэсгэн 7.5 тэрбум еврогийн идэвхжүүлэлт явуулахаар болсон байна. Мөн ХБНГУ-ын Сангийн Сайд ноён Олаф Шольц, хэрэв вирусийн тархалт дэлхийн эдийн засгийн хямралд хүргэх эрсэл дагуулбал ХБНГУ-аас эдийн засгийг идэвхжүүлэх сангийн бодлого явуулахад бэлэн байгаа ба ХБНГУ нь хурдан, үр дүнтэй хөдөлнө гэдгээ мэдэгджээ.

**Япон:** Өнгөрөгч долоо хоногт 9 орчим хувиар буурсан Nikkei индекс, энэ долоо хоногийн Пүрэв гарагт Холбооны нөөцийн сан болон бусад улсуудын төв банкнуудаас гаргасан мэдэгдэлтэй холбоотой өсөлттэй байсан ч Баасан гараг гэхэд COVID-19-ийн тархалт дэлхийн болон Япон улсын эдийн засагт үзүүлэх нөлөөтэй холбоотой бууралттай хаагдлаа.

Японы Төв Банкны ерөнхийлөгч Харухико Курода мэдэгдэлдээ төв банк "цаашдын нөхцөл байдлыг сайтар хянаж, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хөрвөх чадварыг дэмжих замаар хангах болно" гэжээ.

**БНХАУ:** Хөрөнгийн зах зээл нь коронавирусын улмаас дэлхийн эдийн засагт ноцтой нөлөөлөх вий гэсэн болгоомжлол болон төв банкнуудаас цаашид хүүг бууруулах замаар эдийн засагт дэмжлэг үзүүлэх гэсэн хүлээлттэй холбоотой хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй байна. Түүнчлэн БНХАУ-ын эрх баригчид эдийн засгийг дэмжих бодлогын илүү хэрэгжүүлж байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,851.58	-0.92% ▼
Dow Jones	АНУ	25,864.78	1.79% ▲
S&P 500	АНУ	2,972.37	0.61% ▲
Nasdaq	АНУ	8,575.62	0.11% ▲
S&P/TSX	Канад	16,175.02	-0.54% ▼
FTSE 100	Их Британи	6,462.55	-1.79% ▼
S&P/ASX 200	Австрали	6,216.20	-3.49% ▼
Nikkei 225	Япон	20,749.75	-1.86% ▼
Hang Seng	Хонг Конг	26,146.67	0.06% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.75
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	101.24
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.46
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	106.60
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.75
DBM' 2023	USD	7.250%	106.90
TDBM' 2020	USD	9.375%	100.65
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.31

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.863	-0.65 ▼
Libor 3M	0.896	-0.57 ▼
Libor 6M	0.880	-0.52 ▼
Libor 1YR	0.846	-0.54 ▼
US 2YR Bond	0.327	-0.44 ▼
US 3YR Bond	0.376	-0.38 ▼
US 5YR Bond	0.428	-0.39 ▼
US 10YR Bond	0.538	-0.51 ▼

Валютын ханш	2020.03.06	Өөрчлөлт
USD	2,764.36	0.06% ▲
CNY	397.89	0.80% ▲
EUR	3,107.69	2.25% ▲
RUB	40.94	-0.53% ▼
KRW	2.32	1.75% ▲
JPY	26.13	3.00% ▲
CAD	2,063.11	0.42% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,673.83	5.56% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	17.35	4.10% ▲
Зэс	USD/lb.	256.05	0.81% ▲
Нүүрс	USD/MT	66.27	-0.79% ▼
WTI газрын тос	USD/bbl.	41.28	-7.77% ▼
Brent газрын тос	USD/bbl.	45.27	-10.39% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. I	5.6%
Бодлогын хүү	2020. I	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. I	10.86 %
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. I	11.42%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. I	4.74%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. I	17.06%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. I	10.30%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 63 компанийн 398.1 сая төгрөгийн 716,314 ширхэг хувьцаа арилжаалагдав.

"Монгол даатгал" /CHE/ компанийн хувьцаа 32.22%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,190.00 төгрөг хүрч хаагдсан бол "Дархан нэхий" /NEH/ компанийн хувьцаа 14.82%-аар буурч 13,450.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

03-р сарын 06-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,736.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,851.58 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.26%-аар буурсан байна.



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	398.1	
Зах зээлийн үнэлгээ	2,736,405.7	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,851.58	-1.26% ▼
MSE I индекс	9,191.45	-1.97% ▼
MSE II индекс	7,734.17	-1.00% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Инвекор ББСБ	87,838	221,344,393
АПУ	40,946	25,860,979
Улсын их дэлгүүр	17,292	24,618,781
Тавантолгой	3,244	21,366,725
Говь	76,280	17,683,134

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монгол даатгал	1,190.00	32.22% ▲
Увс чацаргана	300.00	25.00% ▲
Ингэттолгой	182.50	15.00% ▲
Техник импорт	8,625.00	15.00% ▲
Мерекс	19.00	11.76% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Дархан нэхий	13,450.00	-14.82% ▼
Авто импекс	1,960.00	-14.78% ▼
Шарын гол	1,100.00	-12.35% ▼
Жуулчин говь	7,900.00	-11.04% ▼
Шивээ овоо	2,090.00	-9.13% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Инвекор капитал	418,761,745
Би Ди Сек	113,515,952
Ард секюритиз	38,535,801
Ти Ди Би Капитал	32,178,915
Гранддевелопмент	31,795,633

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	ЗЗҮ (сая.төг)
АПУ	643.58	684,886
Таван толгой	6,590.00	347,064
МИК Холдинг	14,400.00	298,214
Инвекор ББСБ	2,585.00	185,417
Говь	228.12	177,959

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	NA	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	NA	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	NA	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	NA	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БҮК	2,465.3	526.2	21.3%	4.0	NA	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	NA	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	NA	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	NA	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	NA	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	NA	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	NA	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	NA	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	NA	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	NA	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
30	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377-р тогтоолоор шинэчлэн баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасны дагуу хуралдуулж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.8-д заасан үүргийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал болон холбогдох шийдвэрийг тус Хороонд ирүүлэхдээ дараах хугацааг анхаарч ажиллана уу.

### ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

Дотоодын хөрөнгийн зах зээлд тасралтгүй ахиц дэвшил гарч байгаа хэдий ч цаашид Монгол Улсын эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах, зах зээлийг үсрэнгүй хөгжүүлж, цоо шинэ түвшинд хүргэхийн тулд үнэт цаасны зах зээлийн бүх оролцогч байгууллагууд хамтран дараах хэд хэдэн нэн чухал арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллахыг МХБ-ийн зүгээс нийт зах зээлийн оролцогч байгууллагуудад УРИАЛЖ байна. Үүнд:

1. Мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох
2. Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх
3. Хөрөнгийн зах зээлд татварын бодлогын дэмжлэг бий болгох
4. Хөрөнгийн зах зээлийн өртөг зардлыг бууруулах
5. Иргэдийн хөрөнгийн зах зээлийн оролцоог нэмэгдүүлэх
6. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн найдвартай ажиллагааг хангах



### БУСАД МЭДЭЭ

Компанийн тухай хуульд зааснаар компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулж байхаар зохицуулсан.

Гэхдээ дэлхийн хэмжээнд “COVID-19” коронавируст халдвар дэгдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 62-р тогтоолыг баталж шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020 оны 2-р сарын 13-ны өдрөөс 3-р сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэн, улмаар энэхүү хугацааг 2020 оны 3-р сарын 30-ны өдрийг хүртэл сунгаад байна.

Онцгой нөхцөл байдал үүссэн тул “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй ХК-ууд нь хуульд заасан хугацаанд ээлжит хурлаа хувьцаа эзэмшигчдийг биеэр оролцуулан нэг дор зарлан хуралдуулах боломжгүй болоод байна.

Иймд үүсээд буй нөхцөл байдалд нийцүүлэн хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цуглуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцоог хангуулах зэргээр ээлжит хурлыг өөрийн онцлогт тохирсон боломжтой хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй.

## ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

### ОНЦЛОХ МЭДЭЭ

- 2020 оны эхний 2 сард 4.3 тонн үнэт металл худалдан авлаа.
- Fitch ratings: "Mongolian Mining Corporation"-ийн үнэлгээг "B", хэтийн төлөвийг "тогтвортой" гэж дүгнэв.
- Монголбанк: 2020 онд экспорт 1.6 тэрбум ам.доллаароор буурах төлөвтэй.



### МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Монголбанк 2020 оны эхний хоёр сарын байдлаар нийт 4.3 тн үнэт металл худалдан авсан бөгөөд үүнээс 2020 оны 2-р сард 952 кг үнэт металл худалдан авлаа. Энэ нь өмнөх оны мөн үед 96 кг үнэт металл худалдан авч байснаас 856 кг-аар өссөн үзүүлэлттэй байна.

2020 оны 2-р сард Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 16 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 18 кг үнэт металл тус тус худалдан авсан байна.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 2-р сард 140,292.94 төгрөг байлаа.

### ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Оны эхний 2 сард эрдэс бүтээгдэхүүн, ялангуяа нүүрсний экспорт огцом буурахтай зэрэгцээд Монголбанк энэ жилийн экспортын төлөвөө буурууллаа. Оны эхний хоёр сард Монгол Улсын экспорт 35.9%-аар буурахад нүүрсний экспорт багассан нь голлон нөлөөлжээ.

Үүнээс гадна Төв банк төмрийн хүдрийн экспортын төсөөллийг 720 мянган тонн буюу 53.7 сая ам.доллаароор, нефтийн экспортыг 720 мянган тонн буюу 53.7 сая ам.доллаароор бууруулан тооцсон байна.

Харин зэсийн экспортын биет хэмжээг 5900 тонноор буурах төлөвтэй байгаа ч өмнөх улирлаас үнийн төсөөлөл сайжирч 32.7 сая ам.доллаароор зэсийн экспорт нэмэгдэнэ гэсэн төсөөллийг Монголбанк гаргалаа.



### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.